

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 09 дүгээр сарын 16

№ 24

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын шуурхай хурал 2019 оны 09 дүгээр сарын 16-ний өдрийн 08 цаг 30 минутад Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг дарга С.Насанбат удирдав. Хуралд аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинбат, Т.Ганболд, Тамгын газрын дарга Ч.Энхбат, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /ТЗУХ/-ийн дарга П.Баярсайхан, Хууль эрх зүйн хэлтэс /ХЭЗХ/-ийн дарга Л.Алтанчимэг, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /ХОХБТХ/-ийн дарга П.Батсүх, Нийгмийн бодлогын хэлтэс /НБХ/-ийн дарга Н.Цасчихэр, Санхүү, төрийн сангийн хэлтэс /СТСХ/-ийн дарга Б.Жаргалсайхан, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс /ХШҮДАХ/-ийн дарга Д.Жаргалсайхан, Цэргийн штабын дарга Б.Болдбаатар, Мэдээлэл технологийн алба /МТА/-ны дарга Х.Соёл-Эрдэнэ, Нийтлэг үйлчилгээний алба /НҮА/-ны дарга Б.Золзаяа, Хонгор сумын Засаг дарга Т.Атархишиг, Орхон сумын Засаг дарга Б.Алтансарнай, Захирагчийн ажлын алба /ЗАА/-ны дарга Э.Равжаадэлгэрэх, Орон нутгийн өмчийн газар /ОНӨГ/-ын дарга С.Баясгалан, аймгийн ерөнхий архитектор Д.Элдэвсайхан нар хуралд оролцов. Дархан сумын Засаг дарга Б.Азжаргал чөлөөтэй хуралдааны ирц 94.4 хувьтай байв.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Хэлтэс, агентлагийн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох мэдээ мэдээллийн талаарх тайланг танилцуулах.
2. Шуурхай хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх тайланг танилцуулах

ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР:

Аймгийн Засаг дарга С.Насанбат:

1. Хонгор сумын Засаг даргад: БОАЖЯамны хэн гэдэг, ямар албан тушаалтай хүн баавгайг устгах тухай үүрэг чиглэлийг өгсөн тухай хариуцах эзэнтэй болгож албажуулаарай.
2. ТЗУХэлтэст: Б.Оргилсайханыг ажлаас чөлөөлөх тухай яамнаас үүрэг чиглэл ирүүлсэн гэж байна. Ажлыг энэ 7 хоногт хүлээлцэх
3. Бүх байгууллагын удирдлагуудад: Шуурхай хурлын цагийг ирэх 7 хоногийн 1 дэх өдрөөс эхлэн /2019.09.23/ 08:00 цагт болгоё. Удирдлагууд хүлээн зөвшөөрч байна уу. Санал байхгүй учраас дараагийн шуурхай хурлаас эхлээд цагаа өөрчилъе.
4. ОНӨГазарт: Брак байруудын айл өрхүүд түрээсийн төлбөрөө төлж байна уу. ОНӨГ-аас олон нийтийн саналыг авч хэлэлцүүлгийг зохион байгуулсаны дараа аймгийн ИТХ- хуралд танилцуулах ёстой гэтэл танай байгууллага ажлаа хийхгүй байна. 7 сард айл өрхүүд байрандаа орсон одоо 9 сар дууслаа. Яаралтай энэ ажлыг зохион байгуулж дуусгах ИТХ-ын хуралд оруулах
5. ХШҮДАХэлтэст: Бүх байгууллагын удирдлагуудад: Архивын улсын үзлэгт манай аймаг дэндүү хангалтгүй орлоо. ХШҮДАХ-ийн дарга үүнд анхаарах 6 байгууллагад түүвэрчилсэн шалгалт хийхэд үнэхээр хангалтгүй байсан учраас хяналт шалгалт хийх
6. Тамгын газрын дарга, Т.Ганболд даргад: БСУГазрыг сонгож улсын үзлэгийн шалгалт орно гэж хэлсэн 3 хоногийн дараа шалгахад анх ямар байсан яг тэр

- чигээрээ огт бэлтгэж ажиллаагүй байсан. Энэ байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч хариуцлага тооцох
7. Архивын улсын үзлэгийн салбар комисст: Аж ахуй нэгж байгууллага, агентлагууддаа ахиж шалгаж, хяналт тавьж ажиллах
 8. ӨНОГазарт: Тендерийн сонгон шалгаруулалтын нэгдсэн дүн тайланг танилцуулах, тайлан баланс, бүртгэл, өмч хадгалалт, хамгаалалт, талаарх ажил таг байна. Энэ талаар мэдээ, мэдээлэлдээ тусгах
 9. НБХэлтэс, А.Түвшинбат дарга: Сургууль, цэцэрлэгт нэг бүрчлэн очиж уулзаад сургууль цэцэрлэгийн өвөлжилтын бэлтгэл ажил, дулаан шугам сүлжээний асуудалд анхаарах, БСУГ-ын дарга энэ ажилд огт анхаарахгүй байна. Сургууль, цэцэрлэгийн шугам сүлжээ, өвөлжилтийн бэлтгэл ажил ЗАА болон Засаг даргын ажил юм шиг боллоо. Үүнд анхаарах
 10. НБХэлтэст: Их дээд сургуулиудын оюутнуудыг ногоо хураалтанд хамруулах, Их дээд сургуулийн удирдлагуудтай уулзах А.Түвшинбат даргын өрөөнд уулзалт зохион байгуулж хуваарь гаргах
 11. НБХэлтэст: Т.Ганболд дарга сумдаар явж өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцаж байгаа. Шарын гол сумын 6 дугаар цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн үйл ажиллагаа эхлээгүй байхад БСУГ-ын газрын дарга мэдээгүй байна. Үүнд анхаарах
 12. ХШУДАХэлтэст: ЗДҮАХ-ийн хэрэгжилтийг хэлтэс, хэлтсээр нь гаргаж үнэлэлт, дүгнэлт өгч, удирдлагуудын түвшинд дүйцүүлэх байдлаар дүгнэж ярилцъя.
 13. ХОХБТХэлтэст: Эдийн засаг нийгмийн үүндсэн чиглэлд залуучуудын чуулганаас санал авах, төлөвлөгөөний урьдчилсан төсөл гаргах,
 14. ТЗУХэлтэст: БНСУ- руу явуулах албан бичигт нэмэлт засвар хийж танилцуулах Үүнд: 2020 онд эмч нарыг сургалтад хамруулах, ОБГ-ын алба хаагчдыг сургалтад хамруулах, БНСУ-ын дэмжлэгтэй ухаалаг анги бий болгох талаар тусгах
 15. СТСХэлтэст: Газрын төлбөр барагдуулах ажил ямар түвшинд явагдаж байна. Төлбөр барагдуулалтад анхаарах
 16. ХШУДАХэлтэст: 1500 оюутны чуулга уулзалтад ЗД-ийн илтгэл тавих 2 зааланд зэрэг илтгэл тавигдана. Илтгэлийг маш өндөр хэмжээнд бэлдэх
 17. МТАлбанд: Оюутны чуулга уулзалтыг Форум хэлбэрээр зохион байгуулах тул мэдээ, мэдээллийг сайтар хийх
 18. Бүх байгууллагын удирдлагуудад: ИТХ-ын төлөөлөгчид агентлагийн удирдлагууд үл тоох байдал гаргаж асуудал шийдвэрлэхгүй байгаа талаар гомдол мэдээллэж байна. Удирдлагууд төлөөлөгчдийг үл тоох байдал анхаарах, Жишээ нь: хичээлийн шинэ жилийн нээлтэд тухай тойргийн төлөөлөгчийг уриагүй тухай гэх мэт асуудалд анхаарах, ИТХ-ын хуралдаанд танилцуулагдаж байгаа асуудлуудад байгууллагууд анхаарах.
 19. МТАлбанд: Дижитал шилжилтийн хүрээнд тараах I рад одоо болтол ирээгүй байна. хэдэн долоо хоног болж байна.
 20. Сумдын удирдлагуудад: Хадлан тариалан, ногоо хураалтыг хийх оюунуудыг хүлээж авах
 21. ХЭЗХэлтэст: АТГ-аас ирүүлж байгаа албан бичгийн дагуу тухай байгууллага дээр очиж хяналт шалгалт хийх
 22. ЗААлбанд: Хэдэн албан хаагчид өрөөндөө суугаад гадуур явж ажил хийхгүй байна. Өрөөндөө чихэвч зүүгээд Засаг дарга орж ирж байхад үл тоож байна.
 23. Бүх байгууллагын удирдлагууд: Иргэдийг нааш, цааш явуулахгүй байх, чирэгдүүлэхгүй байхад анхаарах мэдээллийг үнэн зөв тодорхой өгөх, ялангуяа хөдөө орон нутгийн иргэдийг чирэгдүүлэхгүй байхад анхаарах